



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 01 сарын 18 өдөр

Дугаар А/06

Мандалговь

Бэлгийн хүчирхийллийн хохирогчид хүүхэд
хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх тухай

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3, 15.1.4, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 10.1.1, 10.1.2, 10.1.3, 10.1.4, 10.1.5, 10.1.6, 10.2, 11 дүгээр зүйлийн 11.1, 11.5, 11.6 12 дугаар зүйлийн 12.4, 14 дүгээр зүйлийн 14.1, 19 дүгээр зүйлийн 19.1.1, 19.1.4, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/23, 27 дугаар хамтарсан тушаалын Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын нормативын 2 дугаар хавсралт дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийг Улаанбаатар хотод Сэтгэцийн эрүүл мэндийн төвд сэтгэгцэд шинжилгээ хийлгэж, дахин мэдүүлэг өгөх ажлыг 2023 оны 01 дүгээр сарын 10-12-ний өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Бэлгийн хүчирхийллийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх ажлын хэсгийг 1 дүгээр, төсвийг 2 дугаар хавсралтаар баталсугай.

3. Хүүхдийн эрхийн зөрчлийн гомдол мэдээллийг хүлээн авах, нөхцөл байдлын үнэлгээ хийх, аюулгүй байдлыг хангах, дэмжих, холбон зуучлах, хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйлчилгээ үзүүлэх, гэр бүлд нь эргэн нэгтгэх ажлыг хүүхдэд ээлтэй, аюулгүй байдлыг ханган зохион байгуулж, кейс менежментийн явцад хяналт тавьж, хэрэгжилтийг хугацаанд нь тайлагнаж ажиллахыг Хүүхдийн эрхийн улсын байцаагч (Ш.Эрдэнэсүвд)-д үүрэг болгосугай.

4. Үйл ажиллагаанд шаардагдах 825,520 (Найман зуун хорин таван мянга таван зуун хорь) төгрөгийг Хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээний зардлаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (С.Чинбат)-д зөвшөөрсүгэй.

5. Үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2023 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор Даргын дэргэдэх зөвлөлд танилцуулж, ажиллахыг Хүүхдийн эрхийн улсын байцаагч (Ш.Эрдэнэсүвд)-д даалгасугай.

ДАРГА



Ц.ГАНЗОРИГ

482301011

Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд,
залуучуудын хөгжлийн газрын даргын
2023 оны *11* дугаар сарын *11* ний өдрийн
11/16 дугаар тушаалын *1* дүгээр хавсралт




ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ХАРИУ ҮЙЛЧИЛГЭЭ
ҮЗҮҮЛЭХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: Ш.Эрдэнэсүвд
Хүүхдийн эрхийн улсын байцаагч
Гишүүд: С.Батчимэг
Жолооч

---oOo---

Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд,
залуучуудын хөгжлийн газрын даргын
2023 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн
А/а.б тоот тушаалын 11 дүгээр хавсралт



ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ХАРИУ ҮЙЛЧИЛГЭЭ
ҮЗҮҮЛЭХЭД ШААРДАГДАХ ТӨСВИЙН ТООЦОО

№	Хэрэглэгдэхүүн	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Хэдэн удаа	Нийт үнэ
1	Шатахуун А-92	84	2530	1	212,520
2	Томилолт	2	142,000	2	568,000
3	Хоол	1	15,000	1	15,000
4	Оношилгооны төлбөр	1	30,000	1	30,000
Нийт					825,520

---oOo---